

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн Байцгаана уу,

Хаврын улирал эхэлж бид олон арга хэмжээ зохион байгуулж завгүй ажиллаж байна. Энэ долоо хоногт бид Бага Сургуулийн Хөтөлбөр/Сурагчдын Удирдах Хурлын талаар эцэг эхчүүдэд мэдээлэл хийлээ. Энэ амралтын өдрүүдээр бид Стратеги Төлөвлөгөө боловсруулах сургалт зохиох гэж байна. Энэ нь ОУДС-ийн Үйл Ажиллагааны Хэтийн Төлөвлөгөөг боловсруулах ажлын эхний алхам болох юм. Энэ ажлын хэсэгт та бүхэн орж ажиллахыг сонирхож байвал Удирдах Зөвлөлийн Дарга Shane Rosenthal-тай холбоо барина уу. [shane.rosenthal@gmail.com](mailto:shane.rosenthal@gmail.com)

Сурагчдын удирдах хурал 3 сарын 31-нд болно. Хурлын үеэр сурагчид өөрсдийн сурч мэдсэн зүйлээ та бүхэнд тайлбарлах болно. Тэдний сонсогчид нь эцэг эхчүүд, асран хамгаалагчид та бүхэн байх болно.

3 сарын 29-с эхлэн бид Номтой Нөхөрлөх 7 хоног зохион байгуулна. Энэ үеэр та бүхэн хүүхдээрээ ном уншуулаарай. Би сургуулийнхаа зарим ангиудаар орж сурагчдад ном уншиж өгнө. ОУДС-иас зохион байгуулах эдгээр арга хэмжээнүүдэд ирж оролцоорой гэж би та бүхнийг урьж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

**Захирал Greg Rayl**

### **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

3 сарын 29                   Дуртай номынхоо гол баатрын дүрд хувирах өдөр/Номтой Нөхөрлөх 7 хоногт зориулсан өдөрлөг өглөө 8:30-д  
3 сарын 31                   Сурагчдын Удирдах Хурал

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

3 сарын 31-ний Лхагва гарагт Сурагчдын Удирдах Хурал болно. Та бүхэн уулзалтын цагаа хуанлидаа тэмдэглэж хуралд ирж оролцоорой. Энэ хурал жил бүр сургууль даяар зохиогддог бөгөөд 6-12-р ангийн бүх сурагчид оролцоно. Ноднин жил дунд сургуулийн нийт эцэг эхчүүдийн 95% нь хуралд ирж оролцсон. Энэ жил хурлын ирц 95%-с дээш байна гэдэгт бид итгэлтэй байна. Бид өөрсдийн сургууль, хамт олон, багш сурагчдаараа бахархдаг бөгөөд энэ бүх зүйлээ та бүхэнтэй хуваалцахыг хүсэж байна. Энэ өдөр бүх сурагчдын хувьд хичээлийн нэг өдөрт тооцогдох тул та бүхэн хүүхэдтэйгээ ирж хуралд заавал оролцоорой.

Бид энэ амралтын өдрүүдэд Стратеги төлөвлөгөө боловсруулах хуралд оролцоно. Та бүхэн нийт сургуулийн хэтийн төлөвлөгөөг боловсруулах комисст сайн дураар орж ажиллах хүсэлтэй бол бидэнд мэдэгдээрэй. Та бүхэн удирдах зөвлөлийн гишүүдтэй өөрсдийн санал бодол, туслалцаа үзүүлэх боломжийн талаар ярилцаарай. Сургуулийн хамт олон та бүхний санал бодол бидэнд чухал. Бидний үйл ажиллагаа, хичээл зүтгэлд та бүхний туслалцаа хэрэгтэй байдаг.

3-р улирал ирэх долоо хоногт дуусах тул та бүхэн хүүхдүүддээ хичээл сурлагандаа анхаарахад нь дэмжлэг туслалцаа үзүүлээрэй. Ихэнх сурагчид хичээлдээ тогтмол явж сайн суралцаж байгаа ч зарим сурагчдад энэ тал дээр илүү анхаарал, дэмжлэг хэрэгтэй байдаг. Бид өөрсдийн зүгээс тэдэнд дуртайяа тусалдаг бөгөөд манай эцэг эхчүүд гэртээ өөрсдөө хүүхдүүддээ цаг зав гаргаж чадна гэдэгт бид итгэлтэй байна. Та бүхэн хүүхдүүдийнхээ хичээл сургалтын талаар болон сургуулийн талаар асууж ярилцах зүйл байвал бидэнтэй ирж уулзаж ярилцаарай. Та бүхэнтэй нүүр тулан уулзаж ярилцахдаа бид баяртай байх болно.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

### **Сурагчдын Удирдах Хурал**

6-10-р ангийн сурагчид 3 сарын 31-нд болох сурагчдын удирдах хуралд бэлтгэн өөрсдийн судалсан хичээл, хийсэн ажлын тайлангаа нэгтгэж та бүхэнтэй хуваалцахад бэлэн болоод байна. Сурагчид ангидаа хурал удирдаж явуулах өөрсдийн цагаа хуваарилж та бүхэнд товлосон цагаа дуулгах болно. Уулзалтанд бэлтгэж сурагчид маань хурлын үеэр та нарын тэдэнд тавих асуултуудыг бас боловсруулаад байна. Ярилцлага өрнүүлэх зарим нэг асуултуудаас дурдвал:

Чи үүнийг тайлбарлахгүй юу.....  
Чи үүнийг надад үзүүлэхгүй юу.....  
Яагаад .....надад тайлбарлахгүй юу  
.....энэ талаар надад дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу

Дунд Сургуулийн сурагчдын хувьд хурал тус бүр 45 минут үргэлжлэх бөгөөд хурлын төгсгөлд эцэг эхчүүд санал асуулгын хуудас бөглөнө. (Монгол, Англи, Солонгос хэл дээр). Хурлын төгсгөлд та бөглөсөн хуудсаа хүүхдийнхээ анги удирдсан багшид өгөөрэй. Хэрвээ та бүхэнд хурлын явцын талаар асуух асуулт байгаа бол надтай e-мэйлээр холбоо бариарай: d.chilton@isumongolia.edu.mn

**МҮР Хөтөлбөрийн Зохицуулагч David Chilton**

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

### **Номтой Нөхөрлөх 7 хоног:**

Даваа гарагт сурагчид өөрсдийн хайртай номын баатрын дүрд хувилж хувцаслаж ирэх ёстойг анхаарна уу.

### **Сурагчдын Удирдах Хурал:**

3 сарын 31-ний Лхагва гарагт хурлын үеэр бид та бүхэнтэй уулзана.

### **Charlie and the Chocolate Factory:**

Манай жүжгийн тоглолтонд тусалсан бүх эцэг эхчүүдээ дахин баяр хүргэе. Жүжгийн хөтөлбөрт тусалсан эцэг эхчүүдийн нэрс дотор Ae Ran Cho-н нэрийг орхигдуулсандаа хүлцэл өчье. Фото зураг болон DVD захиалах хуудсаа ирүүлсэнд баярлалаа.

Жүжгийн талаарх 2-р ангийн сурагчдын сэтгэгдэл:

“Би ичиж зоволгүй жүжиглэж чадсандаа өөрөөрөө бахархаж байна.”Yo Kyung

“Энэ орой хамгийн сайхан нь манай аав ирсэн явдал. Аав маань маш их ажилтай завгүй байдаг учир тэр болгон сургууль дээр ирээд байдаггүй” Yo Kyung

“Тайзан дээр байхад надад их сайхан байсан. Би өөрийгөө рок од шиг л төсөөлж байсан” Darius

“Энэ оройн хамгийн сайхан хэсэг нь миний тоглосон цахилгаан шатны хэсэг байлаа. Ээжид маань энэ үзэгдэл их таалагдсан” Darius

“Энэ орой хамгийн хэцүү нь эгнээндээ жагсах явдал байлаа. Учир нь бүх хүүхдүүд хашгиралдаад тоглоод байсан” Тэмүүгэ

“Энэ орой жүжиглэх нь хамгийн сайхан санагдсан. Жүжиглэхэд зугаатай байсан.”Тэмүүгэ

“Тайзан дээр байхдаа би бага зэрэг сандарсан” Justus

“Би тод чанга дуугаар шүлгээ уншсан ч миний хоолой бага зэрэг өвдөөд би жоохон хоцроод байсан” Цэрэндорж

“Цахилгаан шатны товч дарахад бага зэрэг хүндрэлтэй байсан учир нь би үгээ хэлээд нэгэн зэрэг товч дарах хэрэгтэй байсан” Энхгэрэл

“Энэ оройн хамгийн сайхан хэсэг нь миний тоглосон хэсэг байсан учир нь ээж маань намайг тоглохыг хүлээгээд сууж байсан” Хишигжаргал

“Тайзан дээр гараад жинхэнэ үзэгчдийг хараад би бага зэрэг айсан” Тэмүүжин

“Тайзан дээр байхдаа би сэтгэл хөдлөөд баяртай байсан” Emre

“Энэ оройн хамгийн сайхан хэсэг нь миний үг хэлсэн хэсэг байсан учир нь ээж аав маань намайг сонсож байсан” Vilakshan

Жүжгийн талаарх 4-р ангийн сурагчдын сэтгэгдэл:

“Эхлээд миний сэтгэл хөдлөөд бага зэрэг сандарсан. Дараа нь би бүх зүйл сайхан болно гэж найдсан. Би бүх эцэг эх, багш нар болон бусад хүмүүсийг хараад бараг ухаан алдах дөхсөн. Би үгээ хэлж дуугаа дуулж дуусаад өөрөөрөө болон бусад сурагчдаар ялангуяа ангийхаа сурагчдаар бахархсан”  
Yash

“Хүмүүс видео бичлэг хийж олон хүмүүс намайг жүжиглэхийг харж байсан учраас би бага зэрэг айсан. Намайг жүжиглэж дуусмагц багш нар маань биднээр бахархаж байсан” Ama

“Би үнэхээр сандарч байсан. Гэхдээ тайзан дээр гараад үгээ хэлээд эхэлмэгцээ сандрахаа болисон. Жүжгэнд тоглоход надад зугаатай сайхан байсан. Бид удахгүй жүжгэнд дахин тоглоно гэж найдаж байна” Kathleen

“Жүжгэнд тоглосон эмээ өвөө нар их сайхан харагдаж байсан. Учир нь тэд хөгшин харагдахын тулд үсэндээ тальк түрхсэн. Бүх сурагчид үнэхээр гайхамшигтай сайн тоглож чадсан гэж би бодож байна”  
Linnea

**Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins**

**Эцэг Эх Багш нарын Бүлгээс**

Бага Сургуулийн жүжиг тоглосон орой ЭББүлэг жигнэмэгийн худалдаа хийж 664,400 төгрөгийн хандив цуглуулсанаа та бүхэнд баяртайгаар мэдэгдэж байна. Энэ бол шинэ амжилт гэдэгт бид итгэлтэй байна.

Жигнэмэгийн худалдаанд оролцсон та бүхэндээ баярлалаа.

**ЭББ-ийн Дарга Berit Adnanes, Kai Ove Berg**